



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 80

Сангиндалай

Сумын тугийг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дүгээр заалтыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 16 дугаар хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Сумын тугийг “Нэгийг харьцах хоёр хэмжээстэй, гуравны хоёр нь цэнхэр, гуравны нэг нь улаан өнгөтэй, цэнхэр өнгөөр мөнх хөх тэнгэрээ шүтэн дээдлэх, улаан өнгөөр сум орон нутаг гал дөл шиг үргэлж өөдөө асан мандаж, хөгжин цэцэглэж байхыг бэлгэдсэн, цэнхэр өнгийн магнай хэсэгт сумын сүлдийг байршуулсан” байхаар хавсралтаар баталсугай.

2. Сумыг тугийг үйлдэх, дүрслэх (оёх, зурах, сийлэх, хэвлэх, хатгах, наах, цоолборлох, барлах)-д иргэд, аж ахуйн нэгж, байгууллага 1 дүгээрт заасныг баримталсугай.

3. Сумын тугийг нийтэд хүртээл болгох ажлыг зохион байгуулж, сурталчлан таниулахыг сумын Засаг дарга (Б.Лхагвамандал), сумын Соёлын төвийн эрхлэгч (Ө.Эрдэнэчимэг)-т даалгасугай.

ДАРГА



Н.ЧУЛУУН

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн  
80 дугаар тогтоолын хавсралт

